



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/149

Арвайхээр

Арвайхээр сумын 2022 оны нөөцийн мах бэлтгэн худалдаанд гаргах тендерийн гүйцэтгэгчийг сонгох үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 2022 оны нөөцийн мах бэлтгэн худалдаанд гаргах тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Ц.Пүрэвсүрэн (Санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч)

Нарийн бичгийн дарга: Ө.Золбаяр (Хотын Захирагчийн албаны мэргэжилтэн)

Гишүүд: Ж.Ганзориг (Нягтлан бодогч)

Б.Доржсүрэн (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

Ц.Оюун (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн)

2. Тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг цахим хэлбэрээр, холбогдох хууль, тогтоомж, заавар журмын дагуу үр дүнтэй зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Ц.Пүрэвсүрэн), гишүүдэд тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ГАНБАТ